

The logo for the Asian Development Bank (ADB) is displayed in white serif font on a dark blue square background.

ADB

**ЭМНЭЛГҮҮДИЙН ЭМНЭЛЗҮЙН ЗАСАГЛАЛД  
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН,  
ГОЛ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

МОН 9701, МОН 3843, МОН 3844 ТӨСӨЛ

Тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний зөвлөх  
Л.Баярцэцэг, С.Дэлгэрэх

## ЭМНЭЛ ЗҮЙН ЗАСАГЛАЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД





## Зорилго:

- Эмнэл зүйн засаглалын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх
- Үнэлгээний үр дүнд үндэслэн эмнэлзүйн засаглалыг бий болгоход шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх

## Хэрхэн хийх вэ?

- Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд эмнэл зүйн засаглалын бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг үнэлэх асуултуудад хариулна.
- Тийм хариулт өгсөн тохиолдолд холбогдох үйл ажиллагаа, түүнийг зохицуулсан дүрэм, журмыг бичнэ.
- Тухайн бүрэлдэхүүн хэсэг байхгүй бол үнэлэхгүйгээр орхиж болно.

№	Асуулт	Холбогдох үйл ажиллагаа, түүнийг зохицуулсан дүрэм, журмыг бичих	Баталгаажуулах
I	<b>Эмнэлзүйн үр дүн</b>		
1.1	Танай эмнэлэг ямар төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг вэ?		
1.2	Тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх стандарт, удирдамжтай юу?		
1.3	Тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх стандарт, удирдамжийг хэн, хэзээ ашигладаг вэ?		
1.4	Танай эмнэлэгт ашиглагддаг эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын жагсаалтыг бичнэ үү		

Эмнэлгүүд эмнэлгийнхээ хүчин чадал, чадавхиас хамаарсан тусламж, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтын дагуу эмнэл зүйн удирдамж, түгээмэл үйлдлийн стандартын жагсаалтаа батлах, эмч, мэргэжилтэн бүрийн ажлын байрны тодорхойлолтод заасан мэдлэгт тохирсон, эзэмшсэн байх ур чадварт нийцүүлсэн мөрдөж ажиллах ёстой стандарт, эмнэл зүйн практикт ашиглах эмнэл зүйн удирдамжийн жагсаалтыг гаргаж, хэн ашиглах, хэрхэн ашиглах, хэзээ ашиглах талаар журамлаж эрх зүйн баримт бичиг болгох

1. Тусламж, үйлчилгээний төрөл гэдгийг тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтэцтэй уялдуулан ойлгож ирсэн хандлага дийлэнх нь байна. Учир нь тусламж, үйлчилгээний төрөл гэдэг нь тухайн эмнэлгийн эмч, мэргэжилтний өөрийнх нь үзүүлж буй эмнэл зүйтэй уялдсан тусламж, үйлчилгээний төрөл гэж ойлгодоггүй.
2. Дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн зүгээс өөрсдийн үзүүлдэг тусламж, үйлчилгээний төрлийг дурьдаж чадаагүй тохиолдолд тухайн тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжийг хэзээ хэрхэн ашигладаг талаар зөв хариулт өгөх боломжгүй юм.
3. Дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд тусламж, үйлчилгээндээ ашигладаг стандарт, удирдамжаа мэдэхгүй байгаа болохоор албан ёсны баталгаажсан “удирдамж, заавар, стандартын жагсаалт” байхгүй байгаа нь тодорхой байна.

II	Эмнэлзүйн аудит/Ижил мэргэжилтний үнэлгээ	
2.1	Танай эмнэлэгт эмнэлзүйн аудит хийх үйл ажиллагаа тогтмол явагддаг уу?	
2.2	Эмнэлзүйн аудит хийх үйл ажиллагаанд танай байгууллагын эмч нар оролцдог уу?	
2.3	Эмнэлзүйн аудит хийх үйл ажиллагаанд өөр байгууллагаас эксперт эмч нарыг урьж ажиллуулдаг уу?	
2.4	Эмнэлзүйн аудит хийх үйл ажиллагаанд зориулсан төсөв байдаг уу?	
2.5	Танай байгууллага үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хэрхэн үнэлдэг вэ?	
2.6	Тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг үнэлэхдээ ямар мэдээлэл цуглуулдаг вэ?	
2.7	Тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг үнэлэх мэдээллийг хэрхэн цуглуулдаг вэ?	
2.8	Тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг үнэлэхээр цуглуулсан мэдээллийг хэн, хэрхэн ашигладаг вэ?	

1. Нийтлэг байгаа зүйл эмнэл зүйн аудитийн талаар ойлголтгүй бөгөөд дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээний эмнэл зүйн үйл явц, үр дүнг үнэлдэг тогтолцоотой байх ёстой, үнэлгээндээ үндэслэж эмнэл зүйн үр дүнгээ сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байх ёстой гэсэн ойлголт бүрэлдэж тогтоогүй.
2. Эмнэл зүйн үйл явцад алдаа, зөрчил гардаг хэрхэн түүнээс урьдчилан сэргийлэх, эмнэл зүйн үр дүн муу байх тохиолдолд тусламж, үйлчилгээний чанар доголдож байдаг тухай ойлголт, хандлага тогтоогүй.
3. Эмнэл зүйн аудитийг ижил мэргэжилтний үнэлгээ төдийгөөр ойлгож хэвшиж ирсэн хандлага ажиглагдаж байна.
4. Эмнэл зүйн аудит нь эмнэл зүйн үйл явцын нэг хэсэг гэж үздэггүй бөгөөд Чанарын албаны ажил гэж дийлэнх эмч мэргэжилтнүүд үздэг байна.
5. Чанарын албанаас хийгддэг хяналт, шалгалтыг ямар зорилготойгоор хийдэг тухай нэгдсэн ойлголт дутмаг, эргэн мэдээлэх тогтолцоо бүрдээгүй, чанар сайжруулах арга хэрэгсэл болж чадаагүй.

III	Эрсдэлийн удирдлага		
3.1	Танай байгууллага эрсдэлийг хэрхэн удирддаг вэ?		
3.2	Танай байгууллага ямар төрлийн эрсдэлийн үнэлгээ хийдэг вэ?		
3.3	Танай байгууллага эрсдэлийг хэрхэн үнэлдэг вэ?		
3.4	Эмнэлгийн ажилтнууд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг гарган тавих тогтолцоо байдаг уу?		

1. Дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд эрсдэлийн удирдлага байхгүй гэж үздэг бөгөөд эрсдэлийн төрлүүдээ мэдэхгүй гэж мөн хариулсан.
2. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг эмнэл зүйн үйл явцын нэг зайлшгүй гэж үздэггүй.
3. Ихэнх эмч, мэргэжилтнүүд эрсдэлээ үнэлдэггүй, чанар, аюулгүй байдалтай холбоотой асуудлыг гаргаж тавих тогтолцоогүй гэж хариулсан.
4. Харин дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд эрсдэлийг удирдах ажил зохион байгуулалтын хувьд хийгдэж эхэлж байгаа гэж хариулсан байна.
5. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг Чанарын алба хариуцдаг гэж мөн дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд хариулсан байна.

Эмнэлгүүд тусламж, үйлчилгээний эмнэл зүйн эрсдэлийн түвшинг тогтоож, маш өндөр, өндөр эрсдэлтэй үнэлгээ авсан тусламж, үйлчилгээ тус бүр дээр эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах



IV	Сургалт ба мэргэшүүлэлт		
4.1	Шинэ ажилтанд зориулсан баримжаа олгох сургалт байдаг уу?		
4.2	Эмнэлгийн мэргэжилтний зайлшгүй хамрагдах сургалт тогтмол явагддаг уу?		
4.3	Эмнэлгийн мэргэжилтнийг хэрхэн мэргэшүүлж, дадлагажуулдаг вэ?		

1. Сургалт ба мэргэшүүлэлттэй холбоотой үйл ажиллагааг дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд хангалтай сайн явагддаг, жигдэрсэн үйл ажиллагаа гэж үздэг байна.
2. Эмнэлгүүд бүгд эмч, мэргэжилтнүүдийн зайлшгүй хамрагдах сургалтын хөтөлбөртэй, сургалт тогтмол явагддаг гэж хариулсан.
3. УБ хотод байршдаг эмнэлгүүдийн эмч, мэргэжилтнүүд мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтыг хангалттай зохион байгуулагддаг гэж дийлэнх нь хариулсан бол, хөдөө орон нутгийн эмнэл ийн эмч, мэргэжилтнүүд сургалтын хэрэгцээ их байдаг, орон нутагт нь мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр зохион байгуулах саналтай гэж хариулсан байна.
4. Сургалт, мэргэшүүлэлтийн үйл ажиллагааг тухайн эмнэлгийн сургалтын алба хариуцдаг, эмнэл зүйн эрхэлсэн орлогч дарга, дэд захирал хариуцдаггүй байна.

V	Үйлчлүүлэгч ба олон нийтийн оролцоо	
5.1	Үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн байгууллагын хооронд тодорхой, нээлттэй харилцаа явагддаг уу?	
5.2	Үйлчлүүлэгчээс ирүүлсэн санал, хүсэлтийг эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад тусгадаг уу?	

1. Эмнэлгийн үйл ажиллагааг зохицуулсан бүх тушаал, шийдвэр, журамд үйлчлүүлэгч болон тэдгээрийн ар гэр, олон нийтийн оролцоог хангасан зохицуулалтыг тусгах
2. Үйлчлүүлэгч, олон нийтээс ирж буй санал гомдлын мөрөөр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шийтгэх бус ажлаа сайжруулах арга хэрэгсэл болгодог хандлагыг тогтоох
3. Тусламж, үйлчилгээг төлөвлөхдөө үйлчлүүлэгч, олон нийтийн эрэлт хэрэгцээг юуны түрүүнд судалдаг байх тогтолцоог бүрдүүлэх

1. Уг бүрэлдэхүүн хэсгийн асуумжид дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд “ тийм” гэсэн хариултыг өгсөн бөгөөд үйлчлүүлэгчдийг үйл ажиллагаандаа оролцуулдаг гэж дүгнэсэн байна. Харин оролцуулдаг байдлаа ямар баримт бичиг, дүрэм, журмаар баталгаажуулсныг авч үзэхэд баталгаажуулах хэсгийг бөглөөгүй байна.
2. Санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэдэг гэж хариулсан байна.
3. Мөн дийлэнх эмнэлэг энэ асуултад сэтгэл ханамжийн судалгаа авдаг, үр дүнг нь тооцож ажилдаа тусган ажилладаг гэсэн хариулт өгсөн байна.



VI	Мэдээлэл ба мэдээллийн технологи	
6.1	Бүх ажилтнууд амархан нэвтрэх боломжтой тохиолдлыг мэдээлэх систем байдаг уу?	
6.2	Эмнэлзүйн үр дүнг бүртгэх системтэй юу?	
6.3	Үйлчлүүлэгчийн эмнэлзүйн мэдээллийг ашиглах эрх эмнэлгийн мэргэжилтний ажил, үүрэгтэй уялдан хийгдсэн үү?	
6.4	Эмнэлзүйн мэдээллийг оруулах загварыг боловсруулахад эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцдог үү?	

1. Эхний асуултад дийлэнх эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд цахим програм ашиглалт хангалтгүй гэж хариулсан байна.
2. Эмнэл зүйн үр дүнг бүртгэх систем байхгүй гэж дийлэнх нь хариулсан.
3. Үйлчлүүлэгчдийн мэдээллийн нууцлал нь эмч, мэргэжилтнүүдийн ажилтай нь уялдаггүй гэж хариулсан.
4. Эмнэлгийн цахим системээс дурын эмч, мэргэжилтэн ямар ч өвчтөний мэдээлэлийг харах боломжтой, хязгарлалтууд байдаггүй, тогтоосон баримталдаг дүрэм журам байдаггүй гэж хариулсан.
5. Эмнэлгийн цахим програм хөгжүүлэлтэд эмч, мэргэжилтнүүдийн оролцоо байдаггүй гэж хариулсан.

VII	Мэргэжлийн хүний нөөцийн удирдлага	
7.1	Байгууллагын хэмжээнд ажилтан бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байдаг уу?	
7.2	Эмч, эмнэлгийн ажилтан бүрийн тухайн ажлын байранд тохирох ур чадварыг үнэлэх үйл ажиллагаа хийгддэг үү?	
7.3	Эмнэлгийн ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлдэг үү? Ямар, ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ? Гүйцэтгэлийг үнэлэхдээ чанар, аюулгүй байдлын хэмжүүрийг ашигладаг үү?	
7.4	Эмнэлзүйн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгаа, ажиллах орчны нөхцөлийг хангах, сайжруулах үйл ажиллагаа явагддаг уу?	

1. Дийлэнх эмнэлгийн хүний нөөцийн алба нь мэргэжлийн хүний нөөцийн удирдлагыг эмнэлгийн бусад хүний нөөцийн удирдлагын асуудалтай хамтад нь авч үздэг тул энэхүү бүрэлдэхүүн хэсгийг “хангагдсан” гэж үзсэн байна.
2. Асуултад хариулсан байдлыг харахад эмч, мэргэжилтнүүдийн нөөцийг удирдах үйл ажиллагааг эмнэл зүйн үйл явцын нэг зайлшгүй хэсэг гэж үздэггүй байна.



Эмнэлгийн “Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал/орлогч дарга”-ын ажлын байрны чиг үүргийг эмнэл зүйн засаглалын 7 бүрэлдэхүүн хэсгийн дагуу тодорхойлж, ажлын байрны тодорхойлолтыг өөрчлөх

- Анагаах ухааны нотолгоонд суурилсан эмнэл зүйн стандарт, удирдамж, заавар, протокол, эмчилгээ, оношилгооны үнэлгээний хуудсыг ашиглан эмнэл зүйн хувьд үр дүнтэй тусламж, үйлчилгээний менежментийг хэрэгжүүлнэ.
- Эмнэл зүйн үр дүнг тогтмол үнэлэх, үнэлгээний үр дүнд суурилсан чанар сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Эмнэл зүйн эрсдэлийг удирдлагыг хэрэгжүүлэх, өвчтөнд учрах хор хөнөөлийг багасгах арга хэмжээг авах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагын механизмыг бий болгоно.
- Эмч, сувилагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар нь хийж буй ажилтай нь нийцсэн байх нөхцлийг бүрдүүлэх, мэдлэг, ур чадварыг нь байнга дээшлүүлэх, мэргэшүүлэхэд тогтмол дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг хариуцана.
- Чанарыг сайжруулахад өвчтөн болон олон нийтийн саналыг ашиглан үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах үйлчилгээг төлөвлөнө.
- Өвчтөнүүдийн мэдээллийн хамгаалалт, нууцлалыг хангахад чиглэсэн эмнэл зүйн менежментийг хэрэгжүүлнэ.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байранд тавигдах шаардлагыг тогтоох, ажлын байрны тодорхойлолыг боловсруулах ажлыг удирдлагаар хангана.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийх, аттестатчлалыг удирдан зохион байгуулах, үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлэх ажлыг хариуцана.



***АНХААРАЛ ТАВЬСАНД  
БАЯРЛАЛАА!***